



ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 02/02

Эрдэнэт

“Ногоон Эрдэнэт” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны ““Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 350 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 58 дугаар зарлиг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 02/02 дугаар тогтоолоор баталсан “Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.3 дахь заалт, 4.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2030 он хүртэлх хугацаанд Орхон аймгийн хэмжээнд 20.0 сая ширхэг мод тарих ажлыг хэрэгжүүлэх “Ногоон-Эрдэнэт” хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, “Ногоон-Эрдэнэт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдүгээр үе шатны арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, “Ногоон-Эрдэнэт” хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр баталж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрт тусгах арга хэмжээг авч, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 12 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

079130004

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Ээлжит VII хуралдааны 07/02 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



“НОГООН-ЭРДЭНЭТ” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчин экосистемийн доройтол, цөлжилт зэрэг байгаль экологийн олон асуудал нь хүн төрөлхтний өмнө сорилт бэрхшээлийг дагуулсаар байгаа билээ. Монгол Улсын Ерөнхийлөгч Эх дэлхий, байгаль орчноо хайрлан, түүнтэй зохицон амьдрах монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах, ой усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх зорилгоор Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж, цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаарх “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2021 оны 10 дугаар сарын 04-ний 58 дугаар захирамж гаргасан.

Орхон аймаг 84.4 мянга га газар нутагтай бөгөөд үүнээс ойн сан бүхий газар 21.9 хувийг эзэлж байна. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж 35.3 га хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламж 15.1 га байгаа нь 1 хүнд ногдох байгууламжийн хэмжээ 4.5м² хүрээд байна. Энэ нь улсын дундаж үзүүлэлтээс 0.3м² аар бага байна.

Орхон аймгийн хувьд 105.4 мянган хүн амтай. 28574 өрхтэй. Нэг км.кв талбайд 115 хүн ногддог ба улсын дунджаас хүн амын нягтралаараа 59.4 дахин, хангайн бүсийн дунджаас 78.0 дахин их байна. Нийт айл өрхийн 61 хувь нь гэр хорооллын багуудад амьдарч байгаа нь агаарын болон хөрсний бохирдлын гол нөхцөл шалтгаан болж байна. Орхон аймагт тулгамдаад буй бас нэг том асуудал нь хаягдлын аж ахуйгаас үүсэж буй цагаан тоос болж байна. Сүүлийн жилүүдэд дэлхийн дулааралтай холбоотой Орхон аймгийн агаарын дундаж температур 1973-аас 2021 оны хооронд 1.8 градусаар дулаарч, орох хур тунадасны хэмжээ, эрчимшил, төрөл нь өөрчлөгдөж байгаа нь байгалийн аюултай үзэгдлийн давтамжийг нэмэгдүүлж байна.

Орчны бохирдлыг бууруулах, байгалийн тэнцвэрт байдлыг хадгалж, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг сайжруулахад мод тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой.

Орхон аймаг, Эрдэнэт хотын “Ногоон Тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025”- ийн зорилт 15-д “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдлыг бууруулж экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална”, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.1.6-т “Хотын төв, гэр холоолол болон хотын ойролцоох суурьшлын бус газруудад үе шаттайгаар ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийг хийж, таримал ойн талбайг нэмэгдүүлнэ”, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1-д “Байгаль орчныг хамгаалах, хүрээлэн буй орчныг бохирдол, аюулыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ”, 4.1.3-т “Хотын доторх ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг стандартын түвшинд хүргэж шинэчилнэ”, 4.1.8-т “Хот орчмын орон нутгийн хамгаалалттай газарт таримал ойн төгөл, ногоон зурвас байгуулж,

жилд ойжуулах талбайг нэмэгдүүлж, тарьц, суулгацын нөөц бүрдүүлнэ” гэж тус тус заасан нь уг хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх гол үндэслэл болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Хөтөлбөрийн зорилго

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 20.0 сая мод тарьж ургуулан байгалийн унаган төрхийг сэргээн, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулж, ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, таримал ой байгуулахад иргэд, олон нийтийн оролцоог дэмжиж нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг 18.0м²-д хүргэж, агаарын чанарыг сайжруулж, иргэдийн эрүүл аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилт

2.2.1. Ойг нөхөн сэргээх, ойн төгөл, ойн зурвас байгуулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, мод үржүүлгийн газруудыг дэмжиж, шинээр байгуулах замаар тарьц, суулгацын хэрэгцээг хангаж, 20.0 сая ширхэг мод тарьж, ойн сангийн талбайг 7.7 хувиар нэмэгдүүлнэ.

2.2.2. Орхон аймгийн нэг хүнд ногдох ногоон байгууламжийн талбайн хэмжээг 4 дахин нэмэгдүүлж, түүний арчилгаа хамгаалалтыг хөгжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.

2.2.3. Ойжуулалт, мод тарилт, ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтын сургалтыг тогтмол зохион байгуулж, мод, бут, сөөг тарьсан, ногоон байгууламж нэмэгдүүлсэн, шинээр байгуулсан иргэн аж ахуйн нэгжийг дэмжиж, урамшуулах, бүртгэлийг цахимжуулна.

2.3. Хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар 2030 он хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

- ✓ 2022-2025 он хүртэл хугацаанд I үе шатыг хэрэгжүүлнэ.
- ✓ 2026-2030 он хүртэл хугацаанд II үе шатыг хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. **Зорилт 1:** Ойг нөхөн сэргээх, ойн төгөл, ойн зурвас байгуулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, мод үржүүлгийн газруудыг дэмжиж, шинээр байгуулах замаар тарьц, суулгацын хэрэгцээг хангаж, 20.0 сая ширхэг мод тарьж, ойн сангийн талбайг 7.7 хувиар нэмэгдүүлнэ.

3.1.1. Ойжуулалтыг технологийн дагуу хийж 7.8 сая мод тарьж, ургуулах.

3.1.2. Төмөр зам, авто зам дагуу ойн зурвас байгуулж 2.9 сая мод тарьж, ургуулах.

3.1.3. Голын голдирол дагуу ойн зурвас байгуулж 3.0 сая мод тус тус тарьж, ургуулан голын урсац болон ундаргыг дэмжих.

3.1.4.Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хаягдлын аж ахуйн цагаан тоосны дэгдэлтийг бууруулах зорилгоор ойн зурвас байгуулж 2.4 сая тарьж, ургуулан тусгай зориулалтын ойн зурвас, ойн төглийг бий болгох.

3.1.5.Газар тариалангийн хамгаалалтын ойн зурвас байгуулж 2.3 сая мод тарьж, ургуулах.

3.1.6.Жимс, жимсгэний агро ойн аж ахуй хөгжүүлж, 0.625 сая жимсний мод тарьж ургуулан эрүүл, чанартай эко бүтээгдэхүүнээр иргэдийг хангах.

3.1.7.Мод үржүүлгийн газруудыг дэмжиж, жилд 4.5 сая ширхэг тарьц, суулгац ургуулах хүчин чадалд хүргэх.

3.2. Зорилт 2: Орхон аймгийн нэг хүнд ногдох ногоон байгууламжийн талбайн хэмжээг 4 дахин нэмэгдүүлж, түүний арчилгаа хамгаалалтыг хөгжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.

3.2.1. Олон зориулалтын ногоон байгууламж байгуулж 2.2 сая мод, бут, сөөг тарьж ургуулах, шарилжгүй хот төслийг хэрэгжүүлэх.

3.2.2.Ногоон байгууламжийн хайс, хашлагыг эдийн засгийн өртөг багатай технологийн шинэлэг хэлбэрийг ашиглан өөрчилж 518.2км урт хамгаалалтын хашааг мод, бут, сөөгний тарилтын үйл ажиллагаатай уялдуулан хийх.

3.2.3.Хотын ногоон байгууламжийн арчилгаа хамгаалалтыг сайжруулан, техник технологийг шинэчлэх, усалгааны шинэлэг систем нэвтрүүлэх.

3.3. Зорилт 3: Ойжуулалт, мод тарилт, ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтын сургалтыг тогтмол зохион байгуулж, мод, бут, сөөг тарьсан, ногоон байгууламж нэмэгдүүлсэн, шинээр байгуулсан иргэн аж ахуйн нэгжийг дэмжиж, урамшуулах, бүртгэлийг цахимжуулна.

3.3.1.Мод тарьсан иргэд, аж ахуйн нэгж шалгаруулж, урамшуулах үйл ажиллагааг журамлах, уламжлал болгон зохион байгуулах.

3.3.2.Цахим бүртгэлийн систем байгуулж, таримал мод, ногоон байгууламжийг бүртгэлжүүлэх.

3.3.3.Мод тарих, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтын олон талт сургалт зохион байгуулж, иргэд, аж ахуйн нэгжүүдийг чадавхжуулах.

3.3.4."Өрх бүр 5 ширхэг мод", "Уламжлалт зан үйлийн таримал ойн төгөл" уриалга гаргаж, мод тарих аяныг зохион байгуулах.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

4.1.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ 2021 оны жилийн эцсийн үзүүлэлтийг суурь болгон явц болон үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	
				Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
1.	Зорилт 1. Ойг нөхөн сэргээх, ойн төгөл, ойн зурвас байгуулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, мод үржүүлгийн газруудыг дэмжиж, шинээр байгуулах замаар тарьц, суулгацын хэрэгцээг хангаж, 20.0 сая ширхэг мод тарьж, ойн сангийн талбайг 7.7 хувиар нэмэгдүүлнэ.	Тарьсан мод, бут, сөөгний тоо	тоо	2021	228761	2030	20сая
2.	Зорилт 2. Орхон аймгийн нэг хүнд ногдох ногоон байгууламжийн талбайн хэмжээг 4 дахин нэмэгдүүлж, түүний арчилгаа хамгаалалтыг хөгжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.	Нэг иргэнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ	м ²	2021	4.5	2030	18.0
3.	Зорилт 3. Ойжуулалт, мод тарилт, ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтын сургалтыг тогтмол зохион байгуулж, мод, бут, сөөг тарьсан, ногоон байгууламж нэмэгдүүлсэн, шинээр байгуулсан иргэн аж ахуйн нэгжийг дэмжиж, урамшуулах, бүртгэлийг цахимжуулна.	Урамшуулалд хамрагдсан иргэн аж ахуйн нэгжийн тоо	тоо	2021	21	2030	309
		Сургалтад хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	тоо	2021	15	2030	2315

Тав. Шаардагдах хөрөнгийн эх үүсвэр

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

5.1.1. Улсын төсөв

5.1.2. Орон нутгийн төсөв

5.1.3. Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн санхүүжилт

5.1.4. Олон нийтийн оролцооны бүлгийн хөрөнгөөр

5.1.5. Бусад

Зургаа. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран гүйцэтгэж дүгнэлт, зөвлөмж бүхий тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын зөвлөлд хүргүүлнэ.

6.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээ, мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

7.1.Аймгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь бусад салбарын оролцоотойгоор хамтран зохион байгуулна.

7.2.Хөтөлбөрийн хэмжээнд хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс гүйцэтгэнэ.

-o0o-

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Ээлжит VII хуралдааны 07/08 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

“НОГООН-ЭРДЭНЭТ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ I ҮЕ ШАТНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ, 2022-2025 (сая.төг)	Суурь түвшин 2021 он	Зорилтот түвшин, үр дүн, төсөв (сая.төг)								Хэрэгжүүлэх байгууллага	
							2022 он		2023 он		2024 он		2025 он			Үндсэн
							Үр дүнгийн үзүүлэлт	Төсөв, сая. төг	Үр дүнгийн үзүүлэлт	Төсөв, сая. төг	Үр дүнгийн үзүүлэлт	Төсөв, сая. төг	Үр дүнгийн үзүүлэлт	Төсөв, сая. төг		
Зорилт 1. Ойг нөхөн сэргээх, ойн төгөл, ойн зурвас байгуулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, мод үржүүлгийн гааруудыг дэмжиж, шинээр байгуулах замаар тарьц, ургуулах.	1	Ойжуулалтыг технологийн хийж 7.8 сая мод тарьж, ургуулах.	2022-2025	Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн санхүүжилт, олон нийтийн оролцооны бүлгийн хөрөнгө, бусад эх үүсвэр	972.0	30 га	48 га	19.0	98 га	135.0	198 га	270	398 га	540.0	БОАЖГ	СДО Анги, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ
							ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг		
Зорилт 2. Төмөр зам, авто дагуу хамгаалалтын ойн зурвас байгуулж 2.9 сая мод тарьж, ургуулах.	2		2022-2025		2258.75	4 га	6 га	65.0	44 га	427.5	103 га	663.75	201 га	1102.5	БОАЖГ	СДО Анги, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ
							ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг		

Зорилто: Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 20.0 сая ширхэг мод тарьж, байгалийн унаган төрхийг сэргээн, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулан, ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, таримал ой байгуулахад иргэд, олон нийтийн оролцоог дэмжиж нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг 18.0 м²-д хүргэж, агаарын чанарыг сайжруулж, иргэдийн эрүүл аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

суулгацын хэрэгцээг хангаж, 20.0 сая ширхэг мод тарьж, ойн сангийн талбайг 7.7 хувиар нэмэгдүүлнэ.	3	Голын голдирол дагуу ойн зурвас байгуулж 3.0 сая мод тарьж, ургуулан голын урсац болон ундаргыг дэмжих.	2022-2025	1761.95	4.9 га	7.9 га	39.7	35.9 га	329.1	80.9 га	506.25	160.9 га	СДО Анги, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ	БОАЖГ	886.9	БОАЖГ	СДО Анги, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ
					2850 ширхэг	7650 ширхэг	119650 ширхэг	299650 ширхэг	614850 ширхэг	122 га	488000 ширхэг	458442 ширхэг					
					-	-	100000 ширхэг	248000 ширхэг	416.25	675.0	528.75	866.25					
4	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хаягдлын аж ахуйн цагаан тоосны дэгдэлтийг бууруулах зорилгоор ойн зурвас байгуулж 2.4 сая мод тарьж, ургуулан тусгай зориулалтын ойн зурвас, төгөл бий болгох.	1372.5	2022-2025	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын зардлаар	4.9 га	7.9 га	-	25 га	281.25	62 га	416.25	122 га	БОАЖГ	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	675.0	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	БОАЖГ
					-	-	100000 ширхэг	248000 ширхэг	416.25	675.0	458442 ширхэг						
					-	-	100000 ширхэг	248000 ширхэг	416.25	675.0	458442 ширхэг						
5	Газар тариалангийн хамгаалалтын ойн зурвас байгуулж 2.3 сая мод	1698.75	2022-2025	Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн	4.9 га	7.9 га	-	31 га	303.75	78 га	528.75	155 га	БОАЖГ, СДО Анги, Жаргалант сумын ЗДТГ	аймгийн ЗДТГ	866.25	аймгийн ЗДТГ	БОАЖГ, СДО Анги, Жаргалант сумын ЗДТГ
					-	5000 ширхэг	86442 ширхэг	227442 ширхэг	528.75	866.25	458442 ширхэг						
					-	5000 ширхэг	86442 ширхэг	227442 ширхэг	528.75	866.25	458442 ширхэг						

Зорилт Орхон аймгийн нэг хүнд ногдох ногоон байгуула- мжийн талбайн хэмжээг дахин нэмэгдүүлж	2.	Олон зориулалтын ногоон байгууламж байгуулж, 2.2 сая мод, бут, сөөг тарьж, ургуулах, шарилжгүй хот төслийг хэрэгжүүлэх	2022- 2025	Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн санхүүжилт, олон нийтийн оролцооны	3088.2	53.8 га	160634	ширхэг	56.8 га	164024	ширхэг	147.2	83.8 га	247076	ширхэг	459.0	156.8 га	471624	ширхэг	1241.0	229.8 га	696172	ширхэг	1241.0	аймгийн ЗДТГ	БОАЖГ, СДО Анги, Жарга- лант сумын ЗДТГ
						678.4	18.98 га	946579	ширхэг	720452	ширхэг	40.0	52 га	1307348	ширхэг	80.0	80.0	52 га	2167148	ширхэг	80.0	52 га	2167148	ширхэг	80.0	52 га
6	Жимс, жимсгэний агро ойн аж ахуй хөгжүүлж, 0.625 сая ширхэг мод тарьж, ургуулан эрүүл, чанартай эко бүтээгдэхүүн ээр иргэдийг хангах.	2022- 2025	санхүүжилт, олон нийтийн оролцооны бүлгийн хөрөнгө, бусад эх үүсвэр	678.4	35 га	-	-	16 га	25600	ширхэг	139.0	39 га	62400	ширхэг	200.1	78 га	124800	ширхэг	339.3	аймгийн ЗДТГ	БОАЖГ, СДО Анги, Жарга- лант сумын ЗДТГ					
					678.4	18.98 га	946579	ширхэг	720452	ширхэг	40.0	52 га	1307348	ширхэг	80.0	80.0	52 га	2167148	ширхэг	80.0	52 га	2167148	ширхэг	80.0	52 га	4245680

иргэдийн ая тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.	2	Ногоон байгууламжийн хайс, хашлагыг эдийн засгийн өртөг багатай технологийн шинэлэг хэлбэрийг ашиглан өөрчилж 518.2км урт хамгаалалтын хашааг мод, бут, сөөгний тарилтын үйл ажиллагаатай уялдуулан хийх.	2022-2025	бүлгийн хөрөнгө, бусад эх үүсвэр	77850.0	5.3 км	12.5 км	120.0	264.4 км	19432.5	475.3 км	19432.5	518.2 км	38865.0	аймгийн ЗДТГ	БОАЖГ, СДОАНГ и, Жаргала нт сумын ЗДТГ
					430.0	21.7%	22.0%	30.0	30%	100.0	40%	150.0	50%	150.0	40.0	149 иргэн, аж ахуйн нэгж
Зорилт 3. Ойжуулалт, мод тарилт, ногоон байгуулам	3	Хотын ногоон байгууламжийн арчилгаа хамгаалалтыг сайжруулж, техник технологийг шинэчлэх, усалгааны шинэ систем нэвтрүүлэх.	2022-2025													ХЗАлба, Цэцэрлэг гжүүлэлт ногоон байгууламжийн газар
	1	Мод тарьсан иргэд, аж ахуйн нэгж шалгаруулж, урамшуулах үйл	2022-2025		150.0	21 иргэн, аж ахуйн нэгж	53 иргэн аж ахуйн нэгж	30.0	85 иргэн, аж ахуйн нэгж	40.0	117 иргэн, аж ахуйн нэгж	40.0	149 иргэн, аж ахуйн нэгж	40.0	аймгийн ЗДТГ	БОАЖГ

жийн арчлалт хамгаалал- тын сургалтыг тогтмол зохион байгуулж, мод, бут, сөөг тарьсан, ногоон байгуу- ламж нэмэгдүүл- сэн, шинээр байгуулсан иргэн аж ахуйн нэгжийг дэмжиж, урамшуу- лах, бүртгэлийг цахимжуул на.	ажиллагааг журамлаж, уламжлал болгон зохион байгуулах	2	Цахим бүртгэлийн систем байгуулж, таримал мод, ногоон байгуулам- жийг бүртгэлжүү- лэх.	2022- 2025	Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн санхүүжилт, олон нийтийн оролцооны бүлгийн хөрөнгө, бусад эх үүсвэр	30.0	-	311.7 га	30.0	347.0 га	-	567.0 га	-	аймгийн ЗДТГ	БОАЖГ
						70.0	1015 иргэн, аж ахуйн нэгж	1015 иргэн, аж ахуйн нэгж	10.0	1315 иргэн, аж ахуйн нэгж	20.0	1515 иргэн, аж ахуйн нэгж	20.0	1815 иргэн, аж ахуйн нэгж	20.0
		4	"Өрх бүр 5 ширхэг мод", "Уламжлалт зан үйлийн таримал ойн төгөл" уриалга гаргаж мод тарих аяныг зохион байгуулах.	2022- 2025		-	5338 өрх	5695 өрх	-	6290 өрх	-	7480 өрх	-	БОАЖГ	Баян- Өндөр, Жаргала нт сумын ЗДТГ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Ээлжит VII хуралдааны 04/02 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт

**“НОГООН-ЭРДЭНЭТ” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН**

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин					Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
			Суурь түвшин	2021 он	2022 он	2023 он	2024 он			
<p>Зорилго: Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 20.0 сая ширхэг мод тарьж, байгалийн унаган төрхийг сэргээн, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулан, ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, таримал ой байгуулахад иргэд, олон нийтийн оролцоог дэмжиж нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг 18.0 м2-д хүргэж, агаарын чанарыг сайжруулж, иргэдийн эрүүл аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ</p>										
<p>Зорилт 1. Ойг нөхөн сэргээх, ойн төгөл, ойн зурвас байгуулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, мод үржүүлгийн газруудыг дэмжиж, шинээр байгуулах замаар тарьц, суулгацын хэрэгцээг хангаж, 20.0 сая ширхэг мод тарьж, ойн сангийн талбайг 7.7 хувиар нэмэгдүүлнэ.</p>										
1	Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн хэмжээ	га	30 га	48 га	98 га	198 га	398 га	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
2	Төмөр зам, авто зам дагуух ойн зурвасын хэмжээ	ширхэг	75000 ширхэг	147000 ширхэг	347000 ширхэг	747000 ширхэг	1547000 ширхэг	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
		га	4 га	2 га	44 га	103 га	201 га	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
3	Голын голдирол дагуу ойн зурвасын хэмжээ	ширхэг	2500 ширхэг	2660 ширхэг	118600 ширхэг	295660 ширхэг	589660 ширхэг	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
		га	4.9 га	7.9 га	35.9 га	80.9 га	160.9 га	2025 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ

		ширхэг	2850 ширхэг	7650 ширхэг	119650 ширхэг	299650 ширхэг	614850 ширхэг	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
4	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хаягдлын аж ахуйн цагаан тоосны дэгдэлтийг бууруулах зориулалтай ойн зурвасын хэмжээ	га	-	-	25 га	62 га	112 га	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
5	Газар тариалангийн хамгаалалтын ойн зурвасын хэмжээ	га	-	4	31	78	155	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
6	Жимс, жимсгэний агро ойн аж ахуйн хэмжээ	ширхэг	-	5000	86442	227442	458442	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
7	Мод үржүүлгийн газруудын нийлбэр хүчин чадлын хэмжээ	га	-	-	16	39	78	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
		ширхэг	-	-	25600	62400	124800	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
		га	18.98	52	52	52	52	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
		ширхэг	946579	720452	1307348	2167148	4245680	жил бүрийн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
Зорилт 2. Орхон аймгийн нэг хүнд ногдох ногоон байгууламжийн талбайн хэмжээг 4 дахин нэмэгдүүлж иргэдийн ая тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.										
1	Олон зориулалтын ногоон байгууламж байгуулжийн хэмжээ	га	53.8	56.8	83.8	156.8	229.8	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
2	Ногоон байгууламжийн хайс, хашлагын хэмжээ	ширхэг	1617500	164024	247076	471624	696172	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
		метр	5.3	12.5	264.4	475.3	518.2	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ

3	Ногоон арчлах байгууламж хамгаалалт	хувь	21.7	22.0	30.0	40.0	50.0	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
Зорилт 3. Ойжуулалт, мод тарилт, ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтын сургалтыг тогтмол зохион байгуулж, мод, бут, сөөг тарьсан, ногоон байгууламж нэмэгдүүлсэн, шинээр байгуулсан иргэн аж ахуйн нэгжийг дэмжиж, урамшуулах, бүртгэлийг цахимжуулна										
1	Урамшуулсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо хэмжээ	иргэн, аж ахуйн нэгж	21	53	85	117	149	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
2	Цахим бүртгэлийн систем бүртгэлжүүлсэн ногоон байгууламжийн хэмжээ	га	-	-	311.7	347.0	567.0	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
3	Сургалтад хамруулж, чадавхжуулсан иргэн аж ахуй нэгжийн тоо	иргэн, аж ахуйн нэгж	15	1015	1315	1515	1815	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ
4	"Өрх бүр 5 ширхэг мод", "Уламжлалт зан үйлийн таримал ойн төгөл" уриалгад хамрагдсан өрхий тоо	өрхийн тоо	5100	5338	5695	6290	7480	2021 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	БОАЖГ